



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/33

Улаанбаатар хот

Эд хөрөнгийн тооллого хийх комисс  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 71, 72 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2.1, Газрын дүрмийн 7.1.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Тус газрын 2022 оны хагас жилийн үндсэн хөрөнгө, материалын тооллого хийх комиссийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга

Гишүүд: Хүний нөөц, ёс зүй дотоод ажил хариуцсан мэргэжилтэн  
Мэдээлэл технологи, цахим хөгжил хариуцсан ажилтан  
Архив, бичиг хэргийн эрхлэгч

Нарийн бичгийн

дарга: Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүд хариуцсан менежер

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдийг мэргэжлийн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг комиссын дарга /Х.Содномдэмбэрэл/-д даалгасугай.

Энэ тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2021 оны А/20 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА *D. Balin* Д.БАТСҮХ



1150590100